



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг
түр хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4, 7.12 дах хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин 7 аймгийн 9 сумын 9 голомтод бүртгэгдэж 20 өрхийн 409 толгой мал өвчилсөн тул мал, амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гоц халдварт шүлхий өвчний тохиолдол бүртгэгдсэн бүс нутгаас мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг тухайн орон нутгийн хорио цээр, хязгаарлалтын дэглэм татан буугдах хүртлэх хугацаанд хориглосугай.

2.Малчдад гоц халдварт, халдварт өвчний талаар мэдээлэл өгөх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулан, мал эмнэлгийн гэрчилгээгүй амьд мал тээвэрлэсэн, тууварласан тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллахыг хорооны Засаг дарга (Н.Нямзав), (Б.Батзориг), Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн менежер (Г.Давгадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД